

## ЦССҮТ, МУЗН-ТАЙ ХАМТРАН “ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТАЙЛАН.

Улаанбаатар хот

2024.01.03

### Үндэслэл:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс санаачлан жил бурийн 3-ны өдрийг “Цусны донорын үндэсний өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсон. Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчлах, ард иргэд тогтмол хугацаанд цусаа өгөхийн ач холбогдлын талаар ойлголт өгөх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд оршдог.

### Зорилго:


#### Цусны донорын бэлтгэл ажлын хүрээнд:

- ✓ ЗМА-ны дарга Ч.Батболд энэ өдрийн хүрээнд зориулах санхүүгийн төсөв гарган ерөнхий захирлаар батлуулсан.
  - ✓ Хамтран ажилласан шилдэг байгууллага, хувь хүний мэдээлэл гаргаж бэлэн болгосон.
  - ✓ Цом өргөмжлөлөө сонголт хийж, эхийг бэлтгэж бэлэн болгосон.
  - ✓ Алдаршуулах донор, байгууллага руу 1 бүрчлэн ярьж 3-ны 10.30-д бэлэн байхаар мэдээллийг 2 удаа хүргэсэн.
  - ✓ Хөтлөгчийн зардал тооцон 2-3 дуу дуулах, хөтлөхөөр гэрээ хийж ажилласан.
  - ✓ Хөтлөгчийн үг, хөтөлбөр, хэвлэлийн мэдээг гарган бэлэн болгов.
- Алдаршуулах донор, байгууллагын шагнал урамшууллын гарын бэлэг МУЗН –тэй хамтран бэлтгэсэн.
- ✓ Зочид төлөөлөгч, донорын зориулсан цайны төсөв батлуулан МУЗН хамтран ажилласан.

#### Нээлтийн үйл ажиллагаа:

Нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 01 сарын 03-ны өдрийн 11 цагт ЦССҮТ-ийн төв байранд зохион байгууллаа.

Нээлтэд ерөнхий захирал АҮ-ны доктор, профессор Н.Эрдэнэбаяр, хамтран зохион байгуулгач МУЗН-ийн НХЭМГ-ийн ахлах ажилтан х. Мөнгөнтуул нар оролцон үг хэллээ.



Цусны доноруудын ач гавьяя нь хүний амь насыг аврах үйлстэй шууд холбогддог учир Монгол Улсын Ерөнхийлөгч 169 дугаар зарлигаар гаргаж 120 ба түүнээс дээш удаа цусаа хандивласан цусны Хүндэт доноруудыг “Шударга журам” медиалаар шагнаж байхаар шийдвэрлэсэн бөгөөд өнөөдөр буюу Цусны донорын Үндэсний өдрөөр Ерөнхийлөгчийн зарлигаар Шударга журам медалиар шагнагдсан 9 хүндэт донорын шагналыг гардуулж гүн хүндэтгэл үзүүллээ.




Уг арга хэмжээний хүрээнд 154 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Баярын Наранзулыг “Алтан донор”-оор, 100 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Тогтохбаярын Эрдэнэбаярыг “Мөнгөн донор”-оор, 70 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Сүхбаатарын Оюуныг “Хүрэл донор”-оор өргөмжилж алдаршууллаа.

2023 онд хамгийн олон удаа цусаа бэлэглэсэн донороор Нямравдангийн Идэржавхлан, Сугирын Хурэлбаатар нар тодорлоо.



ЦССҮТ-ийн шагнал болох “Бахархал 50” тэмдгээр Даваадоржийн Эрдэнэ-Очир, Чогсомын Мөнх-Амгалан, Бахархал 40” тэмдгээр Сангидоржийн Хашцагаан, Отгонбаатарын Гүнбилэгт, “Бахархал 30” тэмдгээр Цэдэндамбын Болдбаяр, Чимэд-Очирын Наранчимэг, “Бахархал 20” тэмдгээр Чанцалмаагийн Жаргалмаа, Насанбатын Батхүү, “Бахархал 10” тэмдгээр Заяатын Энхтуяа, Шагдарын Батсүх нар тус тус шагнагдлаа.



ЦССҮТ-ийн уриалгыг дэмжиж байгууллага хамт олноороо донорын үйлсэд нэгддэг уламжлал хэдийнээ тогтжээ. Өнөөдөр “Цусны донор хамт олон”-оор Дотоодын цэргийн 805 дугаар анги, “Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч шилдэг байгууллага”-аар БЗД-ийн ИТХ-ын ажлын алба, “Донор элсүүлэгч шилдэг байгууллага”-аар АШУҮИС-ийн Залуучуудын Улаан Загалмайн хороо шалгарлаа



Өнөөдрийн арга хэмжээний хүрээнд МУЗН-ийн шагнал “Энэрэл” алтан медалиар цусны донор Б.Уранзул, “Нигүүсэл” алтан медалиар АШҮҮИС-ийн ахлах багш Э.Бат-Өлзий, “Нигүүсэл” мөнгөн медалиар Дотоодын цэргийн 805 дугаар ангийн их эмч, цагдаагийн ахмад О.Гантуяа нарыг шагнаж, хүмүүнлэгийн үйлсэд нь талархал илэрхийлэв.



Энэ өдөр “Хүндэт донор”-ын болзол хангасан 24 доноорт цол тэмдгийг гарын бэлгийн хамт гардууллаа.



МООНРТ-ийн Цагийн хурд, Монголын радио мэдээллийн сувгууд ирж хамtran ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:

МАРКЕТИНГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН АЖИЛТАН

Д.ДУЛМАА